



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/718

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймаг, сум орон нутгийг хөгжүүлэх, бүтээн байгуулалтанд үнэтэй хувь нэмэр оруулсан нэр бүхий иргэд, ардын авъяастнууд, ард иргэдийнхээ амгалан, тайван амьдрах орчин бүрдүүлэх, нийтийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйлсэд өөрийн хувь нэмрээ оруулан ажиллаж буй Цагдаагийн газрын нэр бүхий албан хаагчдыг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 330000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 330000 төгрөг/ гурван зуун гучин мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДУГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
11 дүгээр сарын 05-ны өдрийн
А/ 718 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Олгох шагнал
1	Ч. Цагаан	Буянт сумын өндөр настан	30000
2	Х.Хойчбай	Буянт сумын өндөр настан	30000
3	Э.Болортуяа	Багш, Ардын авъяастан	45000
4.	Н.Энхтуул	Багш, Ардын авъяастан	45000
5.	С.Сумъяа	Сантехникч	45000
6.	О.Янжмаа	Багш, Ардын авъяастан	45000
7.	О.Бекбол	Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн багийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч	30000
8.	М.Айболот	Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн харуулын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч	30000
9.	Н.Нэмэхбаяр	Булган сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн цагдаа-жолооч, цагдаагийн ахлагч	30000
Дүн			330000

-oOo-